

1. “АБТЕМА” дахь гүний гаалийн хяналтын бүсээр 02 дугаар сарын 04-ний өдөр БНХАУ-аас ТСКУ9924602 чингэлгээр импортолсон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх иж бүрдэлд 1 нэрийн 4 кг буюу 94 ширхэг ариутгалын уусмал тээвэрлэлтийн горим зөрчигдөж ачигдсанаас хөлдсөн зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн 1000 нэгж буюу 1000000 /нэг сая/ төгрөгийн шийтгэл ногдуулж, хөлдөж чанарын баталгаагүй болсон тус бэлдмэлийг улсын ахлах байцаагчийн актаар хураан авч, устгуулахаар “Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохиролд нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн зөвлөл”-д шилжүүлж, хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн.



2. Монгол экспресс дэх гүний гаалийн хяналтын бүсээр БНСУ-аас WDFU3019163 тоот чингэлгээр импортолсон 1 нэрийн 3.7 тн, 10 мл-ээр савлагдсан 202980 ширхэг 140056200 төгрөгийн, “Уранитин” нэрийн уусмал эм нь тээвэрлэлтийн горим зөрчигдсөнөөс хөлдсөн зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн 1000 нэгж буюу 1000000 /нэг сая/ төгрөгийн шийтгэл оногдуулж, хөлдөж чанарын баталгаагүй болсон эмэнд шаардлага хангаагүй тухай улсын ахлах байцаагчийн дүгнэлт үйлдэж, гаалийн горимоор устгуулахаар шийдвэрлэв.



3. “АБТЕМА” дахь гүний гаалийн хяналтын бүсээр “Юу И Ди” ХХК-ийн АНУ-аас импортолсон 9.2 тн хатаасан жимс, цагаан будаанд хяналт шалгалт хийхэд импортын гэрчилгээг хуурамчаар үйлдсэн зөрчил илэрсэн тул Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг үндэслэн 5000 нэгж буюу 5000000 /таван сая/ төгрөгийн шийтгэл ногдуулж, хуурамч бичиг баримтын асуудлыг шалгуулахаар Нийслэлийн Цагдаагийн газарт албан тоот хүргүүлээд ажиллаж байна.

4. “АБТЕМА” дахь гүний гаалийн хяналтын бүсээр “Скай хайпермаркет” ХХК-ийн БНСУ-аас импортолсон хүнсний бүтээгдэхүүнийг хяналт шалгалтад хамруулалгүйгээр Монгол улсын хилээр нэвтрүүлсэн тул Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 1000 нэгж буюу 1000000 /нэг сая/ төгрөгийн шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулан ажилласан.

5. “Материал импекс” дэх гүний гаалийн хяналтын бүсээр “Пи Си Жи Эм” ХХК-ийн БНСУ-аас импортолсон 98 кг хоол амтлагчийг хяналт шалгалтад хамруулалгүйгээр монгол улсын хилээр нэвтрүүлсэн тул Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 1000 нэгж буюу 1000000 /нэг сая/ төгрөгийн шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулсан байна.



6. “Материал импекс” дэх гүний гаалийн хяналтын бүсээр иргэн Б.Үүрийнцолмон нь Япон улсаас 43 уут хүүхдийн живхийг хяналт шалгалтад хамруулалгүйгээр хилээр нэвтрүүлсэн тул Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 100 нэгж буюу 100000 /нэг зуун мянга/ төгрөгийн шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулсан байна.

7. “Туушин” дахь гүний гаалийн хяналтын бүсээр “Занаду вайнес” ХХК нь хүнсний бүтээгдэхүүн импортлохдоо хяналт шалгалтанд хамруулалгүйгээр хилээр нэвтрүүлсэн тул Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 1000 нэгж буюу 1000000 /нэг сая/ төгрөгийн шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулан ажиллав.

8. “Прогресс транс” дахь гүний гаалийн хяналтын бүсээр 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Алтан жолоо импекс” ХХК-ийн “Topfer, Etali galaxy” нэрийн 21.4 тн шагшуур, шоколадтай өрмөнцрийг импортлохдоо зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлээгүй зөрчлийг илрүүлж, Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтыг үндэслэн Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17 зүйлийн 7 дахь заалтаар 500 нэгжтэй тэнцэх хэмжээний шийтгэл ногдуулж барагдуулав.



9. “Монголиан сий фүүд” ХХК-ийн БНХАУ улсын “Heilongjiang Qinggang Changlin Meat food” компаниас импортолсон 27.0 тн гахайн махыг 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдөр БНХАУ-аас импортлохдоо Замын-Үүд боомтын Хилийн хяналтын албанаас Нийслэлийн гүний хяналтад шилжүүлсэн боловч гүний хяналт шалгалтад хамрагдаагүй, зайлсхийсэн нь тогтоогдсон тул Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтаар хялбаршуулсан

журмаар зөрчил шалгах ажиллагааг явуулж 1000 нэгж буюу 1.000.000 төгрөгийн арга хэмжээ авч барагдуулж ажилласан.



